



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/114

Бор-Өндөр сум

**Засаг даргын нөөцөөс хөрөнгө
зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Бүсчилсэн хөгжлийн “Иргэдийн спортын наадам”-ыг спортын 7 төрлөөр, 4 үе шаттай Монгол орон даяар зохион байгуулж Бор-Өндөр, Галшар, Дархан сумаас тус бүр 136 тамирчин оролцох тул тэмцээний зардалд 1,898,400 (нэг сая найман зуун ерэн найман мянга дөрвөн зуу) төгрөг, Хэнтий аймагт зохион байгуулагдах Хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох Цэрэг-спортын “ДӨЛ” тэмцээнд Бор-Өндөр сумаа төлөөлөн оролцож байгаа нийт 13 хүүхдийн тээврийн зардал болох 1,190,000 (нэг сая нэг зуун ерэн мянга) төгрөг нийт 3,088,400 (гурван сая наян найман мянга дөрвөн зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 3,088,400 (гурван сая наян найман мянга дөрвөн зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих хууль, дүрмийн дагуу зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ